



**2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮНЭТ ЦААСНЫ
АРИЛЖААНЫ ТАЙЛАН**

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД


1. Үнэт цаасны арилжаа

2024 оны эхний хагас жилд нийт 125 удаагийн үнэт цаасны арилжаа явагдаж, хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 136 ХК-ийн 184.70 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 773.76 сая ширхэг хувьцааг, хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 44.43 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 490.76 мянган ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2.92 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 5.38 сая ширхэг нэгж эрхийг, өрийн хэрэгслийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 565.03 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 5.67 сая ширхэг өрийн хэрэгслийг тус тус арилжиж, нийт 797.08 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийсэн байна.

Нийт арилжааны үнийн дүнгийн 23.17 хувь буюу 184.70 тэрбум төгрөгийг хувьцааны арилжаа, 5.57 хувь буюу 44.43 тэрбум төгрөгийг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны арилжаа, 0.37 хувь буюу 2.92 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа, 70.89 хувь буюу 565.03 тэрбум төгрөгийг өрийн хэрэгслийн арилжаа тус тус эзэлж байна.

НИЙТ АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ

■ Хувьцаа ■ ХБҮЦ ■ Өрийн хэрэгсэл ■ ХОС



Тайлант хугацаанд өдөрт дунджаар 6.37 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 6.28 сая ширхэг үнэт цаас арилжсан байна. Нийт арилжааны үнийн дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.55 дахин өссөн байна.


НИЙТ АРИЛЖААНЫ ХЭМЖЭЭГ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАХАД

ҮНЭТ ЦААС		2023 оны эхний хагас жил		2024 оны эхний хагас жил	
		ширхэг	үнийн дүн	ширхэг	үнийн дүн
ХУВЬЦАА	Анхдагч	563,720,657	324,964,999,471.00	171,555,616.00	24,138,677,184.00
	Хоёрдогч	291,529,039	104,837,315,775.05	602,207,566.00	160,563,137,314.78
ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС	Анхдагч	290,000	29,000,000,000.00	350,000.00	35,000,000,000.00
	Хоёрдогч	137,541	13,202,342,620.00	140,765.00	9,431,631,610.00
ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	Анхдагч	265,000	26,500,000,000.00	5,200,000.00	520,000,000,000.00
	Хоёрдогч	109,195	10,950,566,993.80	472,534.00	45,033,366,210.00
ХАМТЫН ХААЛТТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН	Анхдагч	-	-	-	-
	Хоёрдогч	5,557,992	3,403,324,769.75	5,386,785.00	2,920,786,262.19
Нийт		861,609,424	512,858,549,629.60	785,313,266.00	797,087,598,580.97

1.1 Хувьцааны зах зээлийн арилжаа


Тайлант хугацаанд нийт 125 удаагийн арилжаагаар 136 ХК-ийн 184.70 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 773.76 сая ширхэг хувьцаа арилжигдсанаас 13.07 хувь буюу 24.13 тэрбум төгрөгийн гүйлгээг анхдагч зах зээлийн арилжаа, 86.93 хувь буюу 160.56 тэрбум төгрөгийн гүйлгээг хоёрдогч зах зээлийн арилжаа тус тус эзэлж байна.

ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ



Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 80.17 хувь буюу 128.72 тэрбум төгрөгийн гүйлгээг энгийн арилжаа, 17.64 хувь буюу 28.32 тэрбум төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, 2.19 хувь буюу 3.51 тэрбум төгрөгийн гүйлгээг тендер саналын арилжаа арилжаа тус тус эзэлж байна.

ХУВЬЦААНЫ ХОЁРДОГЧ АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ



Анхдагч зах зээлийн арилжаа

“Ард кредит ББСБ” ХК нийтэд санал болгон нэмж хувьцаа гаргав.

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 428 дугаар тогтоол болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/140 тоот тушаалын дагуу “Ард кредит ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон нэмж гаргасан буй нэг бүр нь 106 төгрөгийн үнэтэй, нийт 8,904,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий 84,000,000 ширхэг хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийг дуустал хугацаанд авч, арилжааг амжилттай зохион байгуулсан.

Анхдагч зах зээлийн арилжаагаар 9,105,862,160 төгрөгийн үнийн дүн бүхий 85,904,360 ширхэг хувьцааг худалдан авахаар 1,583 захиалга ирүүлсэн бөгөөд үнэт цаасны танилцуулга болон андеррайтерийн компаниас ирүүлсэн хуваарилалтын төлөвлөгөөний дагуу стратегийн хөрөнгө оруулагчдын захиалга болон олон нийтээс ирүүлсэн 500,000 төгрөг хүртэлх үнийн дүн бүхий хувьцааны захиалгыг 100 хувь биелүүлж, үлдсэн дүнг 94.6 хувиар хувь тэнцүүлэн хуваарилсан. Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 2/709 албан тоотын дагуу тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөр амжилттай эхлүүлсэн.

“Эм Жи Эл Акуа” ХК нээлттэй компани болов.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 183 дугаар тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/81 тоот тушаал, “Инвескор капитал ҮЦК” ХХК-ийн 2024 оны 05 дугаар сарын 9-ний өдрийн А-24/144 тоот албан бичгийг тус тус үндэслэн “Эм Жи Эл Акуа” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 174 /нэг зуун далан дөрөв/ төгрөгийн үнэтэй, нийт 15,234,677,184 /арван таван тэрбум хоёр зуун гучин дөрвөн сая зургаан зуун далан долоон мянга нэг зуун наян дөрөв/ төгрөгийн үнийн дүн бүхий 87,555,616 ширхэг хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийг дуустал хугацаанд авч, арилжааг амжилттай зохион байгуулсан.

Анхдагч зах зээлийн арилжаагаар нийт 15,277,687,200 /арван таван тэрбум хоёр зуун далан долоон сая зургаан зуун наян долоон мянга хоёр зуу/ төгрөгийн үнийн дүн бүхий 87,802,800 ширхэг хувьцааг худалдан авахаар 485 хөрөнгө оруулагчдаас нийт 501 захиалга ирүүлсэн бөгөөд үнэт цаасны танилцуулга болон андеррайтерийн компаниас ирүүлсэн хуваарилалтын төлөвлөгөөний дагуу стратегийн хөрөнгө оруулагчдын захиалга болон олон нийтээс ирүүлсэн 600 ширхэг буюу 104,400 /нэг зуун дөрвөн мянга дөрвөн зуу/ төгрөг хүртэлх үнийн дүн бүхий хувьцааны захиалгыг 100 хувь биелүүлж, үлдсэн дүнг 98.8 хувиар хувь тэнцүүлэн хуваарилсан. Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 1/2031 албан тоотын дагуу тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр амжилттай эхлүүлсэн.

Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа

Тайлант хугацаанд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 160.56 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 602.20 сая ширхэг хувьцаа арилжсан байна. Нийт 136 ХК-ийн үнэт цаас арилжигдсанаас 85 компанийн үнэт цаасны ханш өсөж, 49 компанийн үнэт цаасны ханш буурч, 2 компанийн үнэт цаасны ханш тогтмол арилжигдсан байна.

ИДЭВХТЭЙ АРИЛЖИГДСАН 30 ХУВЬЦАА

СИМБОЛ	ҮНЭТ ЦААС	ШИРХЭГ	№	СИМБОЛ	ҮНЭТ ЦААС	ҮНИЙН ДҮН
GOV	ГОВЬ	279,751,760	1	GOV	ГОВЬ	71,517,165,605.50
BOGD	БОГД БАНК	80,042,751	2	KHAN	ХААН БАНК	18,576,167,994.00
GAZR	ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР	44,252,013	3	BOGD	БОГД БАНК	6,762,537,985.28
MSE	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ	22,374,717	4	GLMT	ГОЛОМТ БАНК	6,515,214,572.80
LEND	ЛЭНДМН ББСБ ХК	20,789,878	5	APU	АПУ	4,871,206,516.69
CUMN	ПРЕМИУМ НЭКСУС	18,659,680	6	XAC	ХАС БАНК	4,652,324,573.59
KHAN	ХААН БАНК	17,178,593	7	TTL	ТАВАН ТОЛГОЙ	4,294,052,510.00
MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	17,039,053	8	MSE	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ	4,255,139,073.57
SEND	СЭНДЛИ БСББ	16,350,187	9	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,766,252,420.00
QPAY	ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ	12,830,475	10	TDB	ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	3,648,503,520.00
ADB	АРД КРЕДИТ ББСБ ХК	12,549,196	11	INV	ИНВЕСКОР ББСБ	3,642,163,380.00
MLG	МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ	12,373,407	12	SEND	СЭНДЛИ БСББ	2,899,844,257.74
XAC	ХАС БАНК	6,673,669	13	GAZR	ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР	2,817,894,589.78
AMT	ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС	5,954,460	14	CUMN	ПРЕМИУМ НЭКСУС ХК	2,803,402,008.80
MFC	МОНОС ХҮНС	5,609,329	15	QPAY	ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ	2,655,335,171.94
GLMT	ГОЛОМТ БАНК	5,495,887	16	MLG	МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ	2,589,026,745.55
APU	АПУ	4,779,027	17	LEND	ЛЭНДМН ББСБ ХК	1,457,610,853.59
TUM	ТҮМЭН ШУВУУТ	2,330,449	18	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	1,382,825,987.12
NEH	ДАРХАН НЭХИЙ	2,085,629	19	ADB	АРД КРЕДИТ ББСБ ХК	1,325,610,971.34
SBM	ТӨРИЙН БАНК	1,961,107	20	SBM	ТӨРИЙН БАНК	1,000,504,369.70
MBW	МОНГОЛ БАЗАЛТ	1,350,365	21	TAS	ЭРДЭНЭТ ХҮНС	971,996,075.00
AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	1,271,009	22	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН	969,509,611.81
AIC	АРД ДААТГАЛ ХК	1,242,661	23	MNP	МОНГОЛ ШУУДАН	930,531,776.01
MNP	МОНГОЛ ШУУДАН	1,156,400	24	AIC	АРД ДААТГАЛ ХК	880,042,537.01
ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН	986,798	25	TUM	ТҮМЭН ШУВУУТ	783,262,178.03
ITLS	АЙТҮҮЛС	929,093	26	CNF	КРИПТО ҮНДЭСТЭН	625,306,360.00
JTB	ЖЕНКО ТУР БЮРО	809,021	27	TNGR	ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП	591,663,544.00
BODI	БОДЬ ДААТГАЛ	607,585	28	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	577,408,920.00
RMC	РЕМИЖОН	570,608	29	MFC	МОНОС ХҮНС	511,978,859.73
INV	ИНВЕСКОР ББСБ	527,110	30	TAN	ТАХЬ-КО	325,368,360.00
ДУН		598,531,917.00				158,599,871,328.38
НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ		98.51				97.01

ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ 30 ХУВЬЦАА

СИМБОЛ	Үнэт цаас	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт	
				2024.06.27	2023.06.30	/төг/	/хувь/
TVL	ТАВИЛГА	6	83,400	16,980.00	2,412.00	14,568.00	603.98
ECV	ЭРЭЭНЦАВ	1	9,180	9,180.00	1,400.00	7,780.00	555.71
KEK	МОНГОЛ КЕРАМИК	743	3,595,680	5,845.00	1,530.00	4,315.00	282.03
HSX	ХИШИГ УУЛ	751	2,064,471	3,537.00	931.00	2,606.00	279.91
HML	ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГ	1,723	1,935,948	1,440.00	400.00	1,040.00	260.00
NKT	НАКО ТҮЛШ	21,792	809,492	75.90	24.15	51.75	214.29
SON	ЖИДАКС	34,008	20,245,834	588.00	215.00	373.00	173.49
MNS	МОННООС	462	12,857,030	33,700.00	13,000.00	20,700.00	159.23
LEND	ЛЭНДМН ББСБ ХК	20,789,878	1,457,610,854	99.97	40.80	59.17	145.02
TTL	ТАВАН ТОЛГОЙ	177,967	4,294,052,510	27,080.00	11,210.00	15,870.00	141.57
MSE	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ	22,374,717	4,255,139,074	309.52	144.08	165.44	114.83
TEE	ТЭЭВЭР ДАРХАН	309	5,501,980	20,000.00	9,480.00	10,520.00	110.97
UNS	УЛААНСАН	49,474	201,475,782	4,072.00	2,000.00	2,072.00	103.60
HAM	МОНГОЛЫН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	127	317,712	3,236.00	1,610.00	1,626.00	100.99
MNH	МОНГОЛ НЭХЭМЭЛ	763	7,222,580	18,000.00	9,030.00	8,970.00	99.34
ABH	АР БАЯНХАНГАЙ	450	460,208	995.00	508.00	487.00	95.87
DZG	ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ	8,596	1,075,240	155.25	81.45	73.80	90.61
MNG	МАНДАЛ ГОВЬ ИМПЭКС	26	39,826	1,751.00	937.00	814.00	86.87
BTG	БАЯНТЭЭГ	735	21,674,020	37,000.00	20,000.00	17,000.00	85.00
ONH	ӨНДӨРХААН	79	1,185,620	12,500.00	6,905.00	5,595.00	81.03
HVL	ХӨВСГӨЛ	3	439	146.24	83.63	62.61	74.87
TAN	ТАХЬ-КО	27,119	325,368,360	12,000.00	7,000.00	5,000.00	71.43
SHG	ШАРЫН ГОЛ	9,503	8,200,646	1,092.00	648.99	443.01	68.26
GFG	СИЛК НЕТ	115	121,091	1,512.00	900.00	612.00	68.00
NXE	НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ	740	1,567,300	2,180.00	1,380.00	800.00	57.97
HRM	ГЕРМЕС ЦЕНТР	244,867	39,767,811	180.00	115.05	64.95	56.45
SUL	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	1,005	80,894,500	90,000.00	60,000.00	30,000.00	50.00
ALI	СТАНДАРТ НООС	352	238,744	747.50	511.00	236.50	46.28
HRL	ХЭРЛЭН ХИВС	7,576	513,001	79.00	55.00	24.00	43.64
ANH	ХОРИН ХОЁРДУГААР БААЗ	19,873	41,621,038	3,721.00	2,600.00	1,121.00	43.12

ХАНШИЙН БУУРАЛТТАЙ 30 ХУВЬЦАА

СИМБОЛ	Үнэт цаас	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт	
				2024.06.27	2023.06.30	/төг/	/хувь/
TNGR	ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП	88,416	591,663,544	5,000.00	11,920.00	(6,920.00)	(58.05)
AMT	ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС	5,954,460	44,059,019	6.82	15.00	(8.18)	(54.53)
MDR	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	116,483	11,111,668	100.00	175.13	(75.13)	(42.90)
CNF	КРИПТО ҮНДЭСТЭН	12,549	625,306,360	43,000.00	74,500.00	(31,500.00)	(42.28)
JLT	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	26,431	2,551,219	85.00	133.00	(48.00)	(36.09)
MNP	МОНГОЛ ШУУДАН	1,156,400	930,551,776	600.00	919.37	(319.37)	(34.74)
HGN	ХӨХ ГАН	48,092	1,934,917	47.90	67.00	(19.10)	(28.51)
BDL	МОГОЙН ГОЛ	423	4,484,155	11,040.00	15,300.00	(4,260.00)	(27.84)
MIB	МОНИНЖБАР	11,817	573,703	41.25	57.00	(15.75)	(27.63)
ADU	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	33,339	8,765,686	290.00	399.88	(109.88)	(27.48)
TDB	ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	117,209	3,648,503,520	24,980.00	34,000.00	(9,020.00)	(26.53)
ADL	АДУУН ЧУЛУУН	17,353	8,627,533	518.00	695.00	(177.00)	(25.47)
DHU	ДАРХАН ХҮНС	686	1,103,773	1,753.00	2,300.00	(547.00)	(23.78)
APU	АПУ	4,779,027	4,871,206,517	983.93	1,277.00	(293.07)	(22.95)
MDZ	МОНГОЛ ДИЗЕЛЬ	68	469,200	6,900.00	8,830.00	(1,930.00)	(21.86)
DAR	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	88	354,100	4,300.00	5,420.00	(1,120.00)	(20.66)
ETR	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	207,458	27,725,146	115.00	144.90	(29.90)	(20.63)
ADB	АРД КРЕДИТ БЭСБ	12,549,196	1,325,610,971	106.16	133.22	(27.06)	(20.31)
SEND	СЭНДЛИ БЭСБ	16,350,187	2,899,844,258	138.45	170.00	(31.55)	(18.56)
MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	17,539	8,435,454	500.00	600.00	(100.00)	(16.67)
MDIC	МОНГОЛ ДААТГАЛ	34	87,900	2,550.00	3,050.00	(500.00)	(16.39)
AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	1,271,009	3,766,252,420	2,892.00	3,403.00	(511.00)	(15.02)
CHR	УВС ЧАЦАРГАНА	979	357,922	351.00	410.00	(59.00)	(14.39)
BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	15,743	577,408,920	30,300.00	35,000.00	(4,700.00)	(13.43)
AIC	АРД ДААТГАЛ	1,242,661	880,042,537	719.99	831.39	(111.40)	(13.40)
BHG	БӨХӨГ	13	14,855	1,178.00	1,350.00	(172.00)	(12.74)
ATR	АТАР-ӨРГӨӨ	2,905	95,138,020	36,800.00	42,000.00	(5,200.00)	(12.38)
BHL	БӨӨНИЙ ХУДАЛДАА	283	143,153	488.00	555.00	(67.00)	(12.07)
GOV	ГОВЬ	279,751,760	71,517,165,606	262.34	295.00	(32.66)	(11.07)
BUK	УБ-БҮК	58,151	18,309,924	348.00	390.00	(42.00)	(10.77)

Хувьцааны багцын арилжаа

Тайлант хугацаанд 28.32 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 108.60 сая ширхэг хувьцааг багцын арилжаагаар арилжсан байна. Энэ нь нийт хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны үнийн дүнгийн 17.64 хувийг эзэлж байна.

№	СИМБОЛ	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	ШИРХЭГ	ҮНИЙН ДҮН
1	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	270,000	810,000,000.00
2	APU	АПУ	2,484,620	2,413,257,600.80
3	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	13,900	514,300,000.00
4	BOGD	БОГД БАНК	15,971,720	1,348,277,180.00
5	CUMN	ПРЕМИУМ НЭКСУС	6,798,077	815,769,240.00
6	GAZR	ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР	40,000,000	2,609,600,000.00
7	GLMT	ГОЛОМТ БАНК	2,810,631	4,066,481,002.00
8	INV	ИНВЕСКОР БЭСБ	364,342	2,503,263,875.00
9	JGL	ГОВИЙН ӨНДӨР	62,671	10,277,417.29
10	KHAN	ХААН БАНК	1,042,753	1,084,463,120.00
11	MLG	МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ	11,453,819	2,423,872,937.73
12	MNP	МОНГОЛ ШУУДАН	629,738	580,631,030.76
9	QRAY	ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ	12,309,075	2,539,762,147.50
10	SEND	СЭНДЛИ БЭСБ	13,928,357	2,557,342,067.07
11	TAS	ЭРДЭНЭТ ХҮНС	368,536	971,829,432.00
12	TDB	ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	95,560	3,074,780,000.00
ДҮН			108,603,799.00	28,323,907,050.15

Хувьцааны тендер саналын арилжаа

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны "Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн дагуу биржид бүртгэлтэй үнэт цаасыг худалдан авах санал гаргадаг. Тайлант хугацаанд нийт 4 хувьцаат компанийн 3.51 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 12.62 сая ширхэг хувьцааг тендер саналын арилжаагаар арилжсан байна.

№	СИМБОЛ	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	ШИРХЭГ	ҮНИЙН ДҮН
1	GOV	ГОВЬ	12,462,347	3,343,149,206.22
2	HBZ	ХҮННҮ МЕНЕЖМЕНТ	1,200	1,736,448.00
3	UNS	УЛААНСАН	36,684	149,377,248.00
4	JGL	ГОВИЙН ӨНДӨР	119,830	19,650,921.70
		ДҮН	12,620,061.00	3,513,913,823.92

2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

Тайлант хугацаанд анхдагч зах зээлд 35.00 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 350.00 мянган ширхэг, хоёрдогч зах зээлд 9.43 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 140.76 мянган ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас арилжсан байна.

Анхдагч зах зээл

“Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК нийтэд үнэт цаас санал болгов.

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 777 тоот тогтоол болон "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/343 тоот тушаалын дагуу “Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК-ийн нийтэд санал болгон гаргасан жилийн 18 хувийн хүүтэй 24 сарын хугацаатай нэг бүр нь 100,000 төгрөгийн үнэ бүхий 150,000 ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай зохион байгуулагдсан ба Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн 1/29 тоот албан бичгийн дагуу тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2024 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр амжилттай эхлүүлсэн.

“Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК нийтэд үнэт цаас санал болгов.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 87 тоот тогтоол болон "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гүйцэтгэх захирлын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/125 тоот тушаалын дагуу “Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК-ийн олон нийтэд санал болгон гаргасан жилийн 18.5 хувийн хүүтэй 24 сарын хугацаатай нэг бүр нь 100,000 төгрөгийн үнэ бүхий 200,000 ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай зохион байгуулагдсан ба Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 1/1273 тоот албан бичгийн дагуу тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр амжилттай эхлүүлсэн.

3. Хөрөнгө оруулалтын сангийн арилжаа

Тайлан хугацаанд "Үндэсний хувьчлалын сан" болон "Мандал ирээдүйн өсөлт" хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2.92 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 5.38 сая ширхэг нэгж эрхийг арилжсан байна. Үүнээс "Мандал ирээдүйн өсөлт" хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн 1.16 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1.07 сая ширхэг нэгж эрхийг багцын арилжаагаар арилжсан.

СИМБОЛ	Үнэт цаас	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт	
				2024.06.27	2023.06.30	/төг/	/хувь/
XOC	ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН	2,371,885	229,491,526	100.97	103.41	(2.44)	(2.36)
MFG	МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ	3,014,900	2,691,294,736	839.60	752.10	87.50	11.63

4. Өрийн хэрэгслийн арилжаа

Өрийн хэрэгслийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 565.03 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 5.67 сая ширхэг өрийн хэрэгсэл арилжсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 70.89 хувийг эзэлж байна.

"Ашид Капитал ББСБ" ХХК нийтэд үнэт цаас санал болгов.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 45 тоот тогтоол, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/41 тоот тушаалын дагуу "Ашид Капитал ББСБ" ХХК-ийн нийтэд санал болгож буй 18 сарын хугацаатай, жилийн 18 хувийн хүүтэй, нэг бүр нь 100,000 төгрөгийн үнэ бүхий 200,000 ширхэг өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн захиалгыг 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрүүдэд хүлээн авч, арилжааг амжилттай зохион байгуулсан ба санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2208 тоот албан бичгийн дагуу тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2024 оны 06 дугаар сарын 14-ны өдөр амжилттай эхлүүлсэн.


Нийслэлийн засаг даргын хөтөлбөрийн хүрээнд нийтэд өрийн хэрэгсэл санал болгов.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 249 дүгээр тогтоол, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/239 тоот тушаал, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 89 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн засаг даргын хөтөлбөрийн хүрээнд нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн үнэтэй, нийт 500,000,000,000 /таван зуун тэрбум/ төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр хүлээн авч, арилжааг амжилттай зохион байгуулсан.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 1/2323 тоот албан бичгийн дагуу тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдөр амжилттай эхлүүлсэн.

5. Зах зээлийн үнэлгээ

Нийт зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 288.11 тэрбум төгрөг буюу 2.62 хувиар өсөж, 11 их наяд 284.61 тэрбум төгрөг болсон байна.




ХАМГИЙН ӨНДӨР ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭТЭЙ 30 КОМПАНИ


СИМБОЛ	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /төгрөг/
KHAN	ХААН БАНК	1,938,968,772,000.0
TTL	ТАВАН ТОЛГОЙ	1,426,173,616,000.0
TDB	ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	1,264,011,156,460.0
APU	АПУ	1,047,080,155,443.3
GLMT	ГОЛОМТ БАНК	770,561,460,314.3
ХАС	ХАС БАНК	744,448,386,000.0
INV	ИНВЕСКОР ББСБ	522,635,538,900.0
ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН	379,032,105,424.0
SBM	ТӨРИЙН БАНК	362,446,200,000.0
MIK	МИК ХОЛДИНГ	357,235,770,000.0
CUMN	ПРЕМИУМ НЭКСУС	215,050,642,562.0
GOV	ГОВЬ	204,654,713,250.0
MDIC	МОНГОЛ ДААТГАЛ	163,537,469,550.0
SUU	СҮҮ	136,284,775,955.6
MSE	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ	108,475,474,591.3
GTL	ГУТАЛ	104,108,161,000.0
BOGD	БОГД БАНК	101,250,000,000.0
UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	93,080,484,150.0
AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	82,752,448,596.0
LEND	ЛЭНДМН ББСБ	73,907,989,249.5
MLG	МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ	66,900,140,918.0
TUM	ТҮМЭН ШУВУУТ	66,156,000,000.0
MNP	МОНГОЛ ШУУДАН	59,751,817,800.0
MGLA	ЭМ ЖИ ЭЛ АКУА	58,252,490,749.4
GAZR	ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР	57,509,433,936.0
MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	48,052,494,152.0
BUK	УБ-БУК	45,778,530,000.0
QRAY	ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ	42,524,506,800.0
ADB	АРД КРЕДИТ ББСБ	38,642,240,000.0
MFC	МОНОС ХҮНС	38,313,373,607.9
ДҮН		10,617,576,347,409.4
Нийтэд эзлэх хувь		94.09

6. ИНДЕКС

Тайлант хугацаанд TOP-20 индексийн дээд үзүүлэлт 45 024.07 нэгж, доод үзүүлэлт 40 704.45 нэгж, дундаж үзүүлэлт 42 940.88 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 486.02 нэгжээр буюу 20.29 хувиар өсөж, 44 385.18 нэгж болсон байна.



Тайлант хугацаанд MSE-A индексийн дээд үзүүлэлт 18 195.59 нэгж, доод үзүүлэлт 16 294.41 нэгж, дундаж үзүүлэлт 17 061.57 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 007.50 нэгжээр буюу 6.21 хувиар өсөж, 17 223.73 нэгж болсон байна.



Тайлант хугацаанд MSE-B индексийн дээд үзүүлэлт 13 387.44 нэгж, доод үзүүлэлт 11 321.67 нэгж, дундаж үзүүлэлт 12 255.79 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 208.83 нэгжээр буюу 9.93 хувиар өсөж, 13 387.44 нэгж болсон байна.

